

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Газар зүйн мэдээлэл.
Зам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн үзүүлэлт

MNS 6925-8 : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Энэхүү стандартад Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт болон Олон улсын стандартын байгууллага (ISO)-ын 211-р стандартчиллын техникийн хороо (TC211-Geographic information/Geomatics)-ноос гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлага, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон хэсэгчлэн ашигласан.

Монгол Улсын Засгийн газраас үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Сайнбуян, З.Нямбаяр, доктор Б.Баяртунгалаг, А.Түрүүтүвшин, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, Д.Ганпүрэв, Э.Баярмаа, Ж.Дашням, А.Энхбаатар нар хамтран гүйцэтгэсэн.

Монгол Улсын Зөвлөх Инженер Б.Эрдэнэбаатар редакц хийж, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн тээвэр логистикийн багш, доктор. профессор Б.Асралт шүүмжийг хийсэн.

Стандартын төсөлд холбогдох байгууллагуудаас санал, шүүмжийг авч тусгасан.

СХЗГ-ын ахлах мэргэжилтэн доктор Н.Батжаргал “Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006” стандарттай нийцүүлэн хянасан.

Стандартын төслийг “Газрын салбарын стандартчиллын техникийн хороо” /ТХ-36/- ны 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.estandart.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

Агуулга

1 Хамрах хүрээ.....	1
2 Норматив эшлэл	1
3 Нэр томьёо, тодорхойлолт	2
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	2
3.2 Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт	3
4 Техникийн шаардлага.....	4
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага	5
4.2 Атрибутад тавих шаардлага	7
4.3 Кодын жагсаалтад тавих шаардлага	8
4.4 UML диаграммд тавих шаардлага.....	8
4.5 Өгөгдлийн чанарт тавих шаардлага	8
4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зурагт тавих шаардлага.....	9
А хавсралт (норматив) – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	11
В хавсралт (норматив) – Кодын жагсаалт.....	117
С хавсралт (норматив) – UML диаграмм	132
Д хавсралт (норматив) – Өгөгдлийн чанар	140
Е хавсралт (мэдээллийн) – Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг	151
Ном зүй.....	156

Оршил

Энэхүү стандарт нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандарт боловсруулах санаачилгыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачилсан бөгөөд энэхүү асуудлын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамтын оролцоотой бүтсэн баримт бичиг болно.

Стандартын төслийг нь холбогдох байгууллагууд буюу сонирхогч талуудаас өгсөн саналыг авч тусгасан бөгөөд хэрэглэх явцад гарсан дэвшилттэй болон дутагдалтай асуудлын хүрээнд стандартын үзлэгийг цаашид хийгдэх юм.

Стандартаар тогтоосон шаардлагыг хангасны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгох юм.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлсэн.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Энэхүү стандарт нь зам тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Зам тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдөлд тулгуурлан авто зам, төмөр зам, агаарын зам, усан замын бүрэлдэхүүн нэгжийн агуулга, тээвэр, замын төрөл, хурд, тэмдэг, тэмдэглэгээний агуулгатай шинж чанарын мэдээллийг агуулахад оршино.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Зам тээврийн сүлжээний өгөгдлийн үзүүлэлт	MNS 6925-8 : 2021
Geographic information. Data Specification on Road Transport Networks	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн С/36 дугаар тушаалаар батлав

Энэхүү стандартыг Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Зам, тээврийн сүлжээний суурь орон зайн өгөгдлийн сан нь зам, тээврийн нэгдсэн сүлжээ бүхий, авто зам, төмөр зам, усан зам, агаарын зам, тээвэр тэдгээрт хамаарах объектуудаас бүрдэнэ.

Энэхүү стандарт нь зам, тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд зам, тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Огноо заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Огноо заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл;

ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19109:2005, Газар зүйн мэдээлэл – Хэрэглээний схемийн дүрмүүд; ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO/TS 19127:2005, Газар зүйн мэдээлэл – Геодезийн код ба параметрууд;

ISO 19131:2007, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт;

ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;

ISO/DIS 19156, Газар зүйн мэдээлэл – Ажиглалт ба хэмжилт;

*ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
MNS ISO/TS 19104:2012 Газарзүйн мэдээлэл - Нэр томьёо*

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, хөрс, агаар, сансрын, газрын хэвлийн орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрөл

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрөл.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрсэлсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

мета өгөгдөл

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

3.1.8

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадаа ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.9

Домэйн

тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” байх ёстой гэсэн шалгуур домэйн болно.

3.2 Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт**3.2.1****Boolean**

Тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.2**CharacterString**

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт.

3.2.3**CI_Citation**

Эшлэл, хариуцагч эрх бүхий этгээдийн мэдээлэл. [Эх сурвалж: ISO 19115:2003/Cor 1:2006]

3.2.4**Date**

Хугацааг заасан утгын төрөл. Огноо дангаараа болон огноо, цагийн хослол хэлбэрээр байж болно.

3.2.5**DateTime**

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна.

3.2.6**Decimal**

Аравтын бутархайгаар илэрхийлсэн бутархай тоон утга.

3.2.7**Distance**

Объектууд эсвэл цэгүүд хоорондоо хэр зайтай болохыг илэрхийлсэн хэмжилтийн тоон утга юм. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.8**GM_Curve**

Тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл.

3.2.9**GM_Point**

Цэг бол зөвхөн нэг цэгээс бүрдэх геометр объектын өгөгдлийн үндсэн төрөл юм.

3.2.10**GM_Surface**

Гадаргууг дүрсэлдэг, 2 хэмжээст геометрийн суурь дүрслэл.

3.2.11

Integer

Тоон мэдээллийн хуваагаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.12

Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.13

TM_Period

Энэ нь цаг хугацааны цар хүрээг илэрхийлдэг нэг хэмжээст утга юм. Хугацааны утгыг түүний эхлэх ба дуусах түр зуурын утгаар дүрсэлдэг бөгөөд үүний үргэлжлэх хугацаа нь эдгээр хоёр түр зуурын утга хоорондын зайтай тэнцэнэ. [Эх сурвалж: ISO 19108:2002/Cor 1:2006]

3.2.14


Velocity

Биетийн хөдөлгөөний хэмнэлийг дүрсэлсэн тодорхойлолт. Биетийн хурд болон чиглэлийн утгыг агуулна. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутадад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй байна. (1-р зургийг үзнэ үү)



1-р зураг – Тээврийн сүлжээний өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 Орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн А хавсралт норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр тус тусад нь нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Зам тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хавсралтын хүснэгтийн дагуу **Зам, тээврийн нийтлэг элементүүд, Авто замын тээвэр, Төмөр замын тээвэр, Усан замын тээвэр, Агаарын замын тээвэр** гэсэн 5 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Зам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн санд 95 биет төрөл төрөл агуулна.

4.2 Атрибурад тавих шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /ExternalID/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /localID/, “нэрийн талбар” /namespace/, “танигчийн хувилбар” /versionID/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

4.2.4 Зам тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 –д заасан “Газар зүйн нэр” /Geographical Name/ дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Газар зүйн нэр” /Geographical Name/ нь тухайн тухайн байршил дахь газрын нэр “Нэр” /name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газарзүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “MNS 6925-3 : 2021, Газарзүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Зам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн санд 35 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу В хавсралтаас ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграммд тавих шаардлага

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language) диаграммын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна зам тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь зам тээврийн сүлжээний суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.8-р хүснэгтэд үзүүлснээр

дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

ТАЙЛБАР: Эдгээр шаардлага нь олон улсын ISO 19157 стандартад заасан чанарын үзүүлэлтүүд юм. Энэхүү дурдсан ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөх нь олон улсын хэмжээний нэгдсэн үзүүлэлттэй байх зарчимд нийцдэг.

4.5.2 Зам тээврийн сүлжээний суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 “Бүрэн бүтэн байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объектын төрлийн түвшнээс илүү гарах эсвэл дутахгүй байх шаардлагатай.

4.5.2.2 “Утга агуулгын нийцтэй байдал”-ыг хангах шаардлага болох өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд ойлголт, домэйн, формат, топологийн алдаагүй, утга агуулгын хувьд нийцтэй байна.

4.5.2.3 “Байрлалын нарийвчлал”-ыг хангах шаардлага болох орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин байна.

4.5.2.4 “Сэдэвчилсэн нарийвчлал”-ын өгөгдлийн багц, биет төрөл, өгөгдөл төрөл, эдгээрийн атрибут нь үнэн зөв бөгөөд сэдэв агуулгын дагуу байна.

4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зурагт тавих шаардлага

4.6.1 Өгөгдөл бүрдүүлэхдээ агуулгын төрөл ангиллыг ялгах, танихад ашиглах жишээ болгон үзүүлсэн тайлбар зургуудыг Е хавсралтаас ашиглах боломжтой.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Тээврийн сүлжээний орон зайн суурь өгөгдлийн багц ба ангилал

А.1.1 Өгөгдлийн багц: Зам, тээврийн нийтлэг элементүүд (Common transport network)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Тээврийн бүс / <i>Transport area</i> /	«биет төрөл» «feature type»	Полигон	Зам, замын байгууламж, тээврийн сүлжээний бүрэлдэхүүн хэсгийг агуулсан тээврийн сүлжээ элементийн орон зайн хэмжээг илэрхийлдэг гадаргууг илэрхийлсэн талбай.
2	Тээврийн уулзвар, зангилаа / <i>Transport node</i> /	«биет төрөл» «feature type»	Цэг	Сүлжээний эхлэл, төгсгөл, уулзвар, салаа замуудын холболтыг илэрхийлэх цэг орон зайн объект.
3	Тээврийн холбоосны багц / <i>Transport link set</i> /	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн сүлжээнд тодорхой үүрэг, ач холбогдол бүхий нэг тээврийн холбоос болон/эсхүл тээврийн холбоосын дарааллын багцаас бүрдэнэ. Тээврийн холбоосын багц нь салаа салбар зам, тойрог зам, зэрэгцээ зам зэргийг багтаасан болно. Жишээлбэл: тусгаарлах зурвасаар зааглагдсан хоёр зорчих хэсэгтэй хос замыг зорчих хэсэг тус бүрийг илэрхийлсэн хоёр тээврийн холбоос илэрхийлэгдэнэ.
4	Тээврийн холбоосны дараалал / <i>Transport link sequence</i> /	«биет төрөл» «feature type»	Шулуун	Шугаман орон зайн объект нь салбар, салаа замыг оролцуулахгүйгээр тээврийн сүлжээний тасралтгүй үргэлжилсэн трассыг илэрхийлсэн тээврийн холбоосын дэс дараалсан багцаас бүрдэнэ. Тээврийн сүлжээний эхлэлийн цэгээс төгсгөлийн цэг хүртэл дэс дараалсан холбоосыг зөвхөн замын урт гэдэг хэмжигдэхүүнээр илэрхийлж болно. Тээврийн сүлжээ нь нэг болон хэд хэдэн салбарын шинж чанарыг агуулсан байж болно.. Тээврийн холбоосны дэс дарааллыг зорчих хугацаагаар хэмжиж болно.
5	Тээврийн объект / <i>Transport object</i> /	«биет төрөл»	Цэг, шулуун	Тээврийн сүлжээг таних суурь объект. Тээврийн сүлжээг

		«feature type»		танихдаа замын чиглэл дэх газрын нэрийг ихэнх тохиолдолд ашигладаг.
6	Тээврийн холбоос /Transport link/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Замын сүлжээ дэх хоёр цэгийг холбосон хоорондох тээврийн сүлжээний геометр ба холболтыг дүрсэлсэн шугаман орон зайн объект.
7	Тээврийн сүлжээний цэг /Transport point/	«биет төрөл» «feature type»	Цэг	Холбоосны уулзвар бус, цэгийн орон зайн объект нь тээврийн сүлжээн элементийн байрлалыг илэрхийлдэг.
8	Замын тэмдэг /Marker post/	«биет төрөл» «feature type»	Цэг	Замын тэмдэг нь маршрутын дагуу тээврийн сүлжээнд байрладаг, тогтмол давтамжтайгаар, маршрутын эхлэл эсвэл өөр бусад лавлагааны цэгээс тэмдгийг байрладаг цэг хүртэлх зайг заана.
9	Тээврийн өмч /Transport property/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн өмч.
10	Нэвтрэх хязгаарлалт /Access restriction/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Зам, замын байгууламжид нэвтрэх хөдөлгөөний хязгаарлалт.
11	Байгууламжуудын ашиглалтын нөхцөл /Condition of facility/	«биет төрөл» «feature type»	Цэг	Тээврийн сүлжээний элементийн ашиглалт, ашиглалтын байдал.
12	Зам хариуцагч, засвар арчлалтын байгууллага /Maintenance authority/	«биет төрөл» «feature type»	Цэг	Зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдал, өдөр тутмын арчлалт, засварын ажлыг хариуцсан байгууллага.
13	Зам эзэмшигч /Owner authority/	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун	Зам, түүний зурвас газар, холбогдох замын байгууламжийг эзэмшигч эрх бүхий байгууллага.
14	Тээврийн хэрэгслийн хязгаарлалт /Restriction for vehicles/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн элемент дээрх тээврийн хэрэгслийн хязгаарлалт.
15	Замын хөдөлгөөний урсгалын чиглэл /Traffic flow direction/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн холболтын векторын чиглэлтэй холбоотой урсгалын чиглэлийг заана.
16	Босоо чиглэлийн төрөл /Vertical position/	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун	Босоо чиглэлийн төрөл.

17	Тээврийн сүлжээ <i>/Transport network/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун	Нэг төрлийн тээврийн сүлжээнд хамрагдах зам, замын байгууламжуудын багцаар нь ойлгоно. Тээврийн төрөл тус бүрийг (авто тээвэр, төмөр замын тээвэр, усан замын тээвэр, агаарын замын тээвэр) тусад нь авч үзнэ. Эдгээр дөрвөн тээврийн төрлийн хувьд дэд бүтэц, тээврийн хэрэгслийн төрөл, хөдөлгүүрийн систем, ашиглалтын болон бусад шинж чанарт үндэслэн холимог тээврийн төрөл байж болно. Жишээлбэл: зарим тохиолдолд замын бүх төрлүүд нь тээврийн нэг төрөлд хамрагддаг бол зарим тохиолдолд ялангуяа нийтийн тээврийн сүлжээнд тээврийн олон төрлүүд хамрагдаж болно. Усан замын тээврийн хувьд зарим тохиолдолд далайн тээвэр болон дотоодын усан зам усан замын тээвэрт ашигладаг усан онгоц өөр тул тус тусад нь тээврийн төрөл болгон хэрэглэдэг.
18	Нэвтрэх хязгаарлалтын ангилал <i>/Access restriction value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Зам, замын байгууламжид нэвтрэх хөдөлгөөний хязгаарлалт.
19	Байгууламжийн нөхцөлийн ангилал <i>/Condition of facility value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Байгууламжийн нөхцөлийн төрөл.
20	Хязгаарлалтын ангилал <i>/Restriction type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хязгаарлалтын төрөл.
21	Холбоосны чиглэлийн ангилал <i>/Link direction value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Холбоос замын хөдөлгөөний чиглэлийг заана.
22	Босоо чиглэлийн төрлийн ангилал <i>/Vertical position value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Орон зайн объектын харьцангуй босоо байрлал.
23	Тээврийн төрлийн ангилал <i>/Transport type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тээврийн сүлжээний боломжит төрлүүд.

А.1.2 Өгөгдлийн багц: Авто замын тээврийн сүлжээ (Road transport network)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
-----	---------------	--------------	---------------	--------------

1	Авто замын чиг үүрэг <i>/Functional road class/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Энэ ангилал нь авто замын сүлжээнд замын холбоосны чиг үүргийн зэргийг ангилна.
2	Авто замын холбоос <i>/Road link/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Сүлжээн дэх 2 цэгийг холбосон замын геометр болон холболтыг дүрсэлсэн шугаман орон зайн биетийг хэлнэ. Зам холбоос нь холбогдох зам, замын байгууламжуудыг (бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг) холбосон шугам байна.
3	Авто замын хучилтын төрөл <i>/Road surface category/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн хэрэгслийн ачааллыг хүлээн авдаг бөгөөд халтиргаа, үрэлт, цаг уурын нөлөөллөөс замын хучлагыг хамгаалах зориулалттай үеийг авто замын хучилт гэж ойлгоно.
4	Хурдны хязгаар <i>/Speed limit/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаарыг замын хөдөлгөөний дүрмийн тээврийн хэрэгслийн хурд хэсэгт заагдсанаар тогтооно. Хурдны дээд хязгаарын ангилал нь суурин газар, суурин газрын гадна, тууш замд гэж ангилахаас гадна тээврийн хэрэгслийн төрөл, тээвэрлэлтийн төрөл, авто замын ангилал, зэрэглэл, цаг агаарын нөхцөл зэргээс хамаарсан ангиллын утгын авна.
5	Олон улсын чанартай зам <i>/Iroad/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Олон улсын замын сүлжээний нэг хэсэг болох замыг холбосон авто зам.
6	Авто замын холбоосны дараалал <i>/Road link sequence/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Шугаман орон зайн биет нь салбар, салаа авто замыг оролцуулахгүйгээр авто замын сүлжээний тасралтгүй үргэлжилсэн трассыг илэрхийлсэн авто замыг дараалан холбосон багцаас бүрдэнэ. Замын сүлжээний эхлэлийн цэгээс төгсгөлийн цэг хүртэл дэс дараалсан холбоосыг зөвхөн замын урт гэдэг хэмжигдэхүүнээр илэрхийлж болно.

				Замын сүлжээ нь зориулалтаас хамаарч нэг болон хэд хэдэн салбарын шинж чанарыг агуулсан байж болно.
7	Авто замын эгнээний тоо <i>/Number of lanes/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Замын нэг чиглэл дэх эгнээний тоо.
8	Авто замын төрөл <i>/Form of way/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Замын сүлжээний физик шинж чанарт үндэслэсэн ангилал.
9	Авто замын өргөн <i>/Road width/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Хэмжилтийн дундаж утгыг ашиглана.
10	Авто замын бүс <i>/Road area/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Авто замын зорчих болон бусад хэсгийг хамруулсан замын хязгаар доторх гадаргуу.
11	Зам дагуух үйлчилгээний төрөл <i>/Road service type/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, Полигон	Авто зам дагуух үйлчилгээний төрөл болон архитектурын байгууламжийн ангиллаар тодорхойлогдоно. Үүнд: зогсоол, амрах талбай, зам дагуух үйлчилгээний цогцолбор газар, шатахуун түгээх станц, дэлгүүр, зочид буудал, зоогийн газар гэх мэт.
12	Авто зам <i>/Road/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун, полигон	Тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газар бөгөөд зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, таримал зүлэг, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарагдана. Монгол Улсын үндэсний авто замын сүлжээнд хамрагдсан олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж, сайжруулсан болон ердийн хөрсөн хөдөлгөөнд нээлттэй замыг ойлгоно.
13	Авто замын нэр <i>/Road name/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, полигон	Эрх бүхий, хариуцагч байгууллагаас өгсөн авто замын нэр бүхий биет. Жишээлбэл улсын чанартай авто замын сүлжээний үндсэн чиглэл нь А01-А40, дэд чиглэл нь А0101, А0102, А0103, А0104 гэх мэтчилэн нэртэй байдаг бол хотын авто зам нь Энхтайваны өргөн чөлөө, Дилав Хутагтын гудамж, Ард Аюушийн гудамж гэх мэт нэртэй байна.

14	Тээврийн хэрэгслийн зорчих хэсэг /Vehicle traffic area/	«биет төрөл» «feature type»	Полигон	Зорчих хэсгийн гадаргуу.
15	Авто замын уулзвар, зангилаа /Road node/	«биет төрөл» «feature type»	Цэг	Хоёр замын холбоосны хоорондох холболтыг төлөөлөхөд ашигладаг цэгийн орон зайн объект. Энд замын эхлэл, төгсгөл, нэг төвшин дэх уулзвар, олон төвшин дэх огтлол, зам дагуух үйлчилгээний байгууламж, тойрог зам, буцаж эргэх зэрэг багтана.
16	Зам дагуух үйлчилгээний талбай /Road service area/	«биет төрөл» «feature type»	Цэг, Полигон	Авто замын дагуу байрлах, жолооч болон зорчигчдод аяллын явцад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийг техникийн засвар үйлчилгээ, шатах тослох материалаар хангах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байгууламжийн эзлэх талбайгаар хэмжигдэнэ. Жишээлбэл: Шатахуун түгээх станцын талбай, амрах талбай, зам дагуух үйлчилгээний цогцолбор газрын талбай.
17	Авто замын чиг үүргийн ангилал /Functional road class value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Энэ ангилал нь авто замын сүлжээнд замын холбоосны чиг үүргийн зэргийг ангилна.
18	Авто замын хучилтын ангилал /Road surface category value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Энэ ангилал нь замын хучилттай эсэх ангилал юм.
19	Талбайн нөхцөлийн ангилал /Area condition value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хурдны хязгаар нь хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас хамаарна.
20	Хурдны хязгаарын дээд ба доод утга /Speed limit min max value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хурдны хязгаарын утгын жагсаалт.
21	Хурдны хязгаарын эх сурвалжийн ангилал /Speed limit source value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хурдны хязгаарын эх сурвалжийн ангилал.
22	Тээврийн хэрэгслийн төрөл /Vehicle type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хурдны хязгаарлалтад хамаарах тээврийн хэрэгслийн төрөл.
23	Цаг агаарын нөхцөл /Weather condition value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хурдны хязгаарт нөлөөлөх цаг агаарын нөхцөлийн жагсаалт.

24	Замын эгнээний их ба бага утга <i>/Min max lane value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Замын эгнээний тооны хамгийн бага эсхүл хамгийн их хязгаарын утгыг заана.
25	Авто замын төрлийн ангилал <i>/Form of way value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Энэ ангилал нь замын холбоосны физик шинж чанарт үндэслэн ангилал юм.
26	Авто замын бүрдэл хэсэг <i>/Road part value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Авто замыг бүрдүүлэх хэсгүүдийн ангилал.
27	Авто замын үйлчилгээний төрөл <i>/Road service value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Замын үйлчилгээний төрөл.
28	Авто замын улсын код <i>/National road code value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Авто замын улсын код.
29	Авто замын уулзвар, зангилааны ангилал <i>/Form of road node value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Авто замын сүлжээнд байрлах замын уулзварын функцийн төрөл.

А.1.3 Өгөгдлийн багц: Төмөр замын тээврийн сүлжээ (Railway transport network)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Төмөр замын шугам <i>/Railway line/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын сүлжээний зэрэглэл болон нэг буюу хэд хэдэн тодорхойлох шинж чанартай төмөр замын сүлжээний бүрдэл.
2	Төмөр замын уулзвар, зангилаа <i>/Railway node/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Төмөр замын гол шугамын эхлэл, төгсгөл өртөөн дэх холбох ба салбар замын эхлэл, төгсгөл, төмөр замууд нийлж огтлолцсон уулзар зангилаа, зөрлөг, авто замтай хөндлөн огтлолцсон газрууд, өртөө, депогийн байрлал зэрэг нь төмөр замын уулзвар, зангилааны цэгэн орон зайн биет байна.
3	Төмөр замын өртөөний уулзвар <i>/Railway station node/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Өртөөний замын гол шугамтай болон салаа замтай огтлолцож буй цэг, замын эхлэл, төгсгөл, өртөөний замын огтлол, уулзвар, суман шилжүүлгийн байрлалын цэгэн орон зайн объект байна.
4	Төмөр замын цариг <i>/Nominal track gauge/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын царигийн хэмжээ.

5	Төмөр замын ашиглалт <i>/Railway use/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын одоогийн ашиглалт.
6	Төмөр замын талбай <i>/Railway area/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Төмөр замын сүлжээ (зам болон өртөө), замын байгууламжуудын зурвас газар, депо, засварын газар, ачих буулгах талбай болон байгууллага, аж ахуй нэгж, компанийн үйлдвэрийн байгууламж, төхөөрөмж, үйлдвэрийн дэвсгэр нутгийн хоорондох байгууламж зэрэг төмөр замын технологийн үйл ажиллагаа явуулах нийт талбайг ойлгоно.
7	Төмөр замын төрөл <i>/Railway type/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын суурь бүтцийг тээврийн хэрэгслийн төрлөөр нь ангилж илэрхийлсэн шугаман орон зайн объект байна. Үүнд: метроны зам, монорель зам, трамвайн зам г.м.
8	Төмөр замын зураг төслийн хурд <i>/Design speed/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын явах боломжит дээд хурдны тодорхойлолт.
9	Төмөр замын холбоос <i>/Railway link/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын сүлжээн дэх хоёр цэгэн орон зайн биетийг /хоёр RailwayNode/ холбосон замыг дүрсэлсэн шугаман орон зайн биет байна. ТАЙЛБАР: Төмөр замын нэг холбоост нэг болон олон салбар замууд байж болно.
10	Төмөр замын замуудын тоо <i>/Number of tracks/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын шугамыг гол замын тоогоор нь нэг, хоёр, олон замтай гэж ангилна. Монгол Улсад ашиглаж буй төмөр замын сүлжээний шугам нь нэг гол замтай. Хос галт тэрэг явуулахаар төмөр замын шугамыг хүчилтгэсэн тохиолдолд гол замын болон өртөөний замын тоо өөрчлөгдөнө. Өртөө, зөрлөг, гүйцэж түрүүлэх газарт баригдсан салбар замын тооны утгыг авна.
11	Төмөр замын хамгаалалтын бүс <i>/Railway yard area/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Төмөр замын бүсийг тодорхойлдог талбайн орон зайн объект. Төмөр замын хашаа нь: Төмөр замын гол шугамын хөдөлгөөнийг тасалдуулахгүйгээр ачаа ачих / буулгах зорилгоор Ачилт, буулгалтын талбайг ашигладаг, хоорондоо холбогддог хэд хэдэн зэрэгцээ төмөр замын гарцаар дамждаг хэсэг.

12	Төмөр замын холбоосны дараалал <i>/Railway link sequence/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Салбар замыг оролцуулахгүйгээр төмөр замын сүлжээний тасралтгүй үргэлжилсэн трассын дагуу дараалсан төмөр замын шугамыг илэрхийлсэн шугаман орон зайн биет хэлнэ. Замын сүлжээний эхлэлийн цэгээс төгсгөлийн цэг хүртэл дэс дараалсан холбоосыг зөвхөн замын урт гэдэг хэмжигдэхүүнээр илэрхийлж болно. Замын сүлжээ нь зориулалтаас хамаарч нэг болон хэд хэдэн салбар замын шинж чанарыг агуулсан байж болно.
13	Төмөр замын өртөөний код <i>/Railway station code/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Төмөр замын өртөө тус бүрд ногдуулсан давтагдашгүй дугаар.
14	Төмөр замын хамгаалалтын бүсийн зангилаа <i>/Railway yard node/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Төмөр замын хашаан дотор байдаг төмөр замын уулзвар.
15	Төмөр замын цахилгаанжуулалт <i>/Railway electrification/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Төмөр замын тээврийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулагдсан тээврийн хэрэгсэл буюу тусдаа вагонууд болон галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнүүдийг татах зүтгүүр нь цахилгаан тэрэг ажиллаж байгаа эсэхийг илэрхийлнэ.
16	Төмөр замын өртөөний талбай <i>/Railway station area/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Өртөө (галт тэрэг хүлээн авах явуулах, зөрүүлэх, гүйцэж түрүүлэх, ачаа хүлээн авах олгох, зорчигчдод үйлчлэх тавцан, талбай, агуулахтай, галт тэрэг найруулах, задлах, галт тэрэгний бусад техникийн ажиллагаа хийж болох замын хэсэглэх газар), өртөөний төвлөрүүлэлтийн байрны (сум ба дохионы удирдлагыг төвлөрүүлсэн өртөөний байр) хамрах газрыг илэрхийлэх талбайн орон зайн объект байна.
17	Төмөр замын уулзвар, зангилааны төрөл <i>/Form of railway node value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Төмөр замын уулзвар, зангилааны цэгэн орон зайн биетийн ангиллын утга болно.
18	Төмөр замын царигийн төрөл <i>/Track gauge category value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Төмөр замын өргөний ангилал.

19	Төмөр замын ашиглалтын төрөл <i>/Railway use value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Төмөр зам хэрэглээний төрөл.
20	Төмөр замын төрлийн ангилал <i>/Railway type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Төмөр замын суурь бүтцийг тээврийн хэрэгслийн төрлөөр нь ангилан илэрхийлсэн шугаман орон зайн объектын ангиллын утга.
21	Төмөр замуудын их, бага тоон утга <i>/Min max track value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Зэргэлдээ байрлах төмөр замын замуудын хамгийн их болон хамгийн бага тоон утгыг тодорхойлно.

А.1.4 Өгөгдлийн багц: Усан замын тээврийн сүлжээ (Water transport network)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Усны зангилаа <i>/Water node/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Усны тээврийн сүлжээнд хоёр өөр усан замын холболт ба голын холбоосын хоорондох холболтыг илэрхийлэхэд ашигладаг цэгийн орон зайн объект.
2	Усан замын уулзвар, зангилаа <i>/Waterway node/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Усны тээврийн сүлжээнд хоёр өөр усан замын холболт ба голын холбоосны хоорондох холболтыг илэрхийлэхэд ашигладаг цэгийн орон зайн объект.
3	Усан боомтын зангилаа <i>/Port node/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Далайн болон далайн боомтын орон зайн уулзвар цэг, ойролцоо боомтын усан сангийн эрэгт байрладаг.
4	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах схем <i>/Traffic separation scheme/</i>	«биет төрөл» «feature type»	Шулуун	Эсрэг чиглэлд шилжиж буй хөдөлгөөнийг тусгаарлах, уулзварт мөргөлдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн схем.
5	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах бүс <i>/Traffic separation scheme area/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах схемийн нэг хэсэг болох орон зайн объект.
6	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах гарц <i>/Traffic separation scheme crossing/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зам хөндлөн гарах тодорхой газар.
7	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах эгнээ	«биет төрөл» «feature type»	Цэг	Нэг чиглэлийн хөдөлгөөний урсгалыг тогтоосон хязгаарт багтаасан талбай.

	/Traffic separation scheme lane/			
8	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сааруулах тойрог зам /Traffic separation scheme roundabout/	«биет төрөл» «feature type»	Цэг	Тодорхой цэг эсвэл бүсийн эргэн тойронд цагийн зүүний эсрэг чиглэлд шилжих хөдөлгөөнийг салгах схем.
9	Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг салгах бүдүүвч /Traffic separation scheme separator/	«биет төрөл» «feature type»	Цэг	Усан онгоцнуудын эгнээг тусгаарлах бүс; эсвэл ижил чиглэлд явж буй хөлөг онгоцны тодорхой ангилалд зориулагдсан замын эгнээ тусгаарлах.
10	Усан зам /Waterway/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Усан замын тээврийн хэрэгслийг аюулгүйгээр зорчиход тогтоосон хөвөлтийн болон бусад дохио, тэмдэг бүхий байгалийн болон хиймлээр барьж байгуулсан усан зурвасыг
11	Дотоодын усан зам /Inland waterway/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Орон нутгийн усан замын сүлжээнд усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх боломжтой гол, мөрөн, нуур
12	Гэрэлт цамхаг /Beacon/	«биет төрөл» «feature type»	Цэг	Усан онгоцыг хөвөхөд ашигладаг зам заагч гэрэл.
13	Усан замын холбоос /Waterway link/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Усан сүлжээний орон зайн шугаман объект, энэ нь тасралтгүй үргэлжлэх замыг илэрхийлнэ.
14	Усан замын боомтын талбай /Port area/	«биет төрөл» «feature type»	Полигон	Далайн болон далайн боомтын хуурай газрын бүсийг бүрдүүлдэг бүх байгууламжийн хязгаарыг илэрхийлэхэд ашигладаг орон зайн объект.
15	Усан байгууламжийн төлөв /Condition of water facility/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Усан замын тээврийн сүлжээний элементийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын байдал.
16	Усан холбоосны дараалал /Water link sequence/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Усан сүлжээний орон зайн шугаман объект, энэ нь тасралтгүй үргэлжлэх замыг илэрхийлнэ.
17	Усан замын тээврийн хэрэгслийн аяллын талбай /Fairway area/	«биет төрөл» «feature type»	Цэг	Томоохон гол, мөрөн, нууруудад усан замын тээврийн хэрэгслээр аялал зохион байгуулахад зориулан орон нутгийн захиргааны байгууллагаас тогтоосон хэсэг
18	Усан замын тээврийн хэрэгслийн хязгаарлалт	«биет төрөл» «feature type»	Шулуун	Усан замын тээврийн элемент дээрх тээврийн хэрэгслийн хязгаарлалт.

	/Restriction for water vehicles/			
19	Усан замын дохио тэмдэг /Buoy/	«биет төрөл» «feature type»	Цэг	Усан замын тээврийн хэрэгслийг аюул осолгүй удирдах, жолоодоход туслах зорилгоор гол, мөрөн нуурын эрэгт болон усны мандал дээр тодорхой байршилд байрлуулсан усан замын бүх төрлийн тэмдэг, тэмдэглэгээ
20	Усан замын уулзвар, зангилааны төрөл /Form of waterway node value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Усан замын сүлжээний уулзвар.

А.1.5 Өгөгдлийн багц: Агаарын замын тээврийн сүлжээ (Air transport network)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Агаарын замын зангилаа /Air node/	«биет төрөл» «feature type»	Цэг	Агаарын тээврийн сүлжээний зангилаа.
2	Аэродромын уулзвар, зангилаа /Aerodrome node/	«биет төрөл» «feature type»	Цэг	Аэродромын байршлыг хялбаршуулсан хэлбэрээр буюу цэг хэлбэрээр дүрсэлдэг цэгэн объект.
3	Үндсэн цэг /Designated point/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын хөлгийн явах нислэгийн замын тодорхойлох зэрэгт ашигладаг газар зүйн байршил.
4	Навигаци /Navaid/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Нислэг хийж байхад зүг чиг, баримжаа заахад тусалдаг тэмдэглэгээ. Ихэвчлэн гэрэлт цамхаг, хөвүүр гэх мэт хамаарна.
5	Хөөрч буух зурвасын шугамын дагуу байрлах цэг /Runway centreline point/	«биет төрөл» «feature type»	Цэг	ХБЗ-ийн шугамын дагуу байрлах цэг.
6	Газардах, хөөрөх хэсэг /Touch down lift off/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Нисдэг тэрэг газардах болон хөөрөхөд зориулсан даац сайтай хэсэг.
7	Агаарын шугаман холбоос /Air link/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын сүлжээний холболтыг тодорхойлдог орон зайн шугаман объект.
8	Агаарын замын холбоос	«биет төрөл»	Шулуун	Дараалсан хоёр цэгээр тодорхойлогдсон завсрын

	/Air route link/	«feature type»		зогсоолгүйгээр нисэх маршрутын хэсэг
9	Буултын зурвасын холбоос /Procedure link/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Урьдчилан тодорхойлсон хөөрөлтийг саад бэрхшээлээс урьдчилан сэргийлэх хамгаалалт.
10	Нисэн гарах журмын дээд өндөр /Upper altitude limit/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын замын дээд өндөр.
11	Явгалах зам /Taxiway area/	«биет төрөл» «feature type»	Полигон	Агаарын хөлгийн явгалах болон аэродромын нэг хэсгийг нөгөө хэсэгтэй нь холбох зориулалттайгаар аэродром дээр тогтоосон тодорхой замыг хэлнэ. Үүнд: (а) Зогсоолын /агаарын хөлгийн/ явгалах шугам /Aircraft stand taxi lane/ - зөвхөн агаарын хөлгийн зогсоолд хүрэхэд зориулагдсан явгалах зам буюу перроны хэсэг (б) Перроны явгалах зам /Apron taxiway/- Перроныг хөндлөн нэвтрэн явгалахад зориулагдсан, перрон дээр байрлах явгалах замын системийн нэг хэсэг (в) Хурдны явгалах зам /Rapid exit taxiway/- ХБЗ-ыг эзлэх хугацааг багасгах зорилгоор буулт үйлдэж байгаа агаарын хөлөг өндөр хурдаар зурвасыг чөлөөлөхөд зориулагдсан, хөөрч буух зурвастай хурц өнцгөөр холбогдсон явгалах зам.
12	Нисэх зурвасын өндөр /Field elevation/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Онгоцны нисэх буух талбайн хамгийн өндөр цэг, далайн түвшний хоорондох босоо зай.
13	Ашиглалтын хязгаар /Use restriction/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын тээврийн сүлжээг ашиглах хязгаарлалт.
14	Аэродромын бүс /Aerodrome area/	«биет төрөл» «feature type»	Полигон	Агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тогтоосон газар болон усан гадаргуу, түүний дээр байрлах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн хам тойлгодог.
15	Перрон /Apron area/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Перрон нь зорчигчдыг буулгаж суулгах, ачаа, эсхүл шууданг ачих буулгах, агаарын хөлгийг сумлах, байрлуулах, эсхүл техник үйлчилгээ хийхэд зориулагдсан газрын аэродромын тодорхой хэсэг.

16	Агаарын зай /Airspace area/	«биет төрөл» «feature type»	Полигон	"Монгол Улсын агаарын зай" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших хийн мандлын агаарын давхаргын орон зайг ойлгоно.
17	Нисэн ирэх журам /Standard instrument arrival/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Чухал шаардлагатай цэгүүдийг холбож агаарын хөлөг буух чиглэлийг тодорхойлдог нислэгийн зааварчилгаа.
18	Нисэн гарах журам /Standard Instrument Departure/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Чухал шаардлагатай цэгүүдийг холбож агаарын хөлөг хөөрөх чиглэлийг тодорхойлдог нислэгийн зааварчилгаа.
19	Аэродромын төрөл /Aerodrome type/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Аэродром гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тогтоосон газар болон усан гадаргуу, түүний дээр байрлах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн хамт ойлгоно.
20	Хөөрч буух зурвасын хучилт /Surface composition/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Хөөрч буух зурвасын хучилтыг ойлгоно. Асфальт, асфальт бетон, хөрсөн, зассан шороон гэх мэт ангилдаг.
21	Нисэн гарах журмын нам өндөр /Lower altitude limit/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Нислэг үйлдэх аюулгүй нам өндөр.
22	Ойртолт үйлдэх журам /Instrument approach procedure/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын хөлөг буулт хийх үед ашигладаг буулт эхлэхээс газардаж дуусах хүртэлх нарийвчилсан зурвас бүхий чиглэл.
23	Агаарын зам /Air route/	«биет төрөл» «feature type»	Полигон	Агаарын зам гэж хонгил хэлбэрээр тогтоогдсон агаарын хөлгийн удирдлагатай бүс, эсхүл түүний хэсгийг ойлгоно.
24	Нислэг үйлдэхэд ашиглах тоног төхөөрөмжийн нөхцөл /Condition of air facility/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын тээврийн сүлжээний элементийн ашиглалт, ашиглалтын байдал.
25	Хөөрч буух зурвасын талбай /Runway area/	«биет төрөл» «feature type»	Полигон	Агаарын хөлгийн буулт, хөөрөлтөд зориулан тоноглож бэлдсэн аэродромын тэгш өнцөгт талбайг хэлнэ.
26	Аэродромын ангилал /Aerodrome category/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Онгоцны буудлын ангилал ба агаарын тээврийн үйлчилгээний цар хүрээ, ач холбогдлын талаар.
27	Агаарын холбоосны дараалал /Air link sequence/	«биет төрөл» «feature type»	Шулуун	Агаарын холболтын захиалгат цуглуулгаас бүрдсэн шугаман орон зайн объект бөгөөд агаарын замын сүлжээнд тасралтгүй үргэлжлэх замыг илэрхийлнэ.

28	Навигацийн тоног төхөөрөмжийн ангилал / <i>Navaid type value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Навигацийн ангилал.
29	Нислэгт ашиглах цэгийн үүргийн утга / <i>Point role value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Нислэгт ашиглах цэгийн үүргийн утга.
31	Агаарын замын холбоосны ангиллын утга / <i>Air route link class value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Нислэгийн маршрутын төрөл.
32	Агаарын замын хэрэглээний хязгаарлалт / <i>Air use restriction value</i> /	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Агаарын сүлжээний объектын ашиглалтын хязгаарлалт.
